



**НАЛАЙХЫН БАРИЛГЫН МАТЕРИАЛЫН
ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК ОНӨААТҮГ
ДАРГЫН ТУШААЛ**

2017 оны 04 сарын 04 өдөр

Дугаар Д/15

Улаанбаатар хот

ХӨРӨНГӨ ГАРГАХ ТУХАЙ

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4.18, 16.5.5 дугаар заалт, “Налайхын барилгын материалын үйлдвэрлэл технологийн парк” орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газрын дүрмийн 5 дугаар зүйлийн 5.1.8 дахь заалт, хөдөлмөрийн дотоод журмын 9.18 дахь хэсгийг үндэслэн ТУШААХ НЬ:

1. Инженер Г.Пүрэвдоржид ар гэрийн гачигдал гарч төрсөн ах нь нас барсан тул нэг удаагийн мөнгөн тусламж үзүүлсүгэй.
2. Дээрх зардалд 300,000 /гурван зуун мянган/ төгрөгийг нэг удаагийн тэтгэмж, урамшуулалын зардлаас гаргахыг ахлах нягтлан бодогч /Ц.Бямбасүрэн/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА  А.БОЛДБААТАР

